

## Гарчиг

1.	ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА .....	2
1.2.	Төслийн товч танилцуулга .....	2
1.3.	Уурхайн календарьчилсан төлөвлөгөө.....	3
1.4.	Уурхайн ажиллах горим .....	3
1.5.	Уулын ажлын төлөвлөгөө .....	3
1.6.	Ил уурхайн ашиглалтын систем .....	3
1.7.	Баяжуулах технологи .....	5
2.	БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА .....	7
2.1.	Цаг уур, уур амьсгал .....	7
2.2.	Усан сүлжээ .....	7
2.3.	Хөрсний төлөв байдал .....	7
2.4.	Амьтны аймаг .....	7
2.5.	Тариалан сумын нийгэм эдийн засгийн судалгаа .....	8
3.	ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ .....	9
4.	БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ .....	10
5.	СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	11
5.1.	Ордын ашиглалтын үед сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө .....	11
5.2.	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө .....	14
5.3.	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	14
5.4.	Нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө .....	15
5.5.	Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө.....	15
5.6.	Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө .....	16
5.7.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө .....	16
6.	ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР .....	19
6.1.	БОМТ-ний хэрэгжилтийн талаар нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төлөвлөгөө .....	20

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.	Төслийн талбайн координат цэг	2
Хүснэгт 2.	Жилд ажиллах хоног	3
Хүснэгт 3.	Ашиглалтын системийн үндсэн элементүүд	4
Хүснэгт 4.	“НЭТЭНТ” ХХК-ийн өөрийн эзэмшлийн тоног төхөөрөмжүүдийн жагсаалт	4
Хүснэгт 5.	Хөрс хуулалт, элс олборлолтонд ажиллах экскаваторын техникийн үзүүлэлт	4
Хүснэгт 6.	Экскаваторуудын бүтээл, хэрэгцээний тооцоо	5
Хүснэгт 7.	Нуурын багтаамж	6
Хүснэгт 8.	Болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээний нэгдсэн дүн	9
Хүснэгт 9.	Ордын ашиглалтын үед сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	11
Хүснэгт 10.	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө, зардал	14
Хүснэгт 11.	Нөхөн сэргээлтийн зардал	15
Хүснэгт 12.	Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	15
Хүснэгт 13.	Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө	16
Хүснэгт 14.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардал	17
Хүснэгт 15.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал	19
Хүснэгт 16.	БОМТ тайлагнах төлөвлөгөө	20
Хүснэгт 17.	БОМТ-ний нийт зардал	20

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.	Төслийн талбайн байршил.....	2
Зураг 2.	Угаан баяжуулах цехийн тоног төхөөрөмжийн холболтын бүдүүвч .....	6

## 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 1.1. Төслийн ерөнхий мэдээлэл

**Төсөл хэрэгжүүлэгч:** “Шинэст өргөө” ХХК

УБД: 1511002011, РД: 4001621

**Төслийн нэр:** “Улаан ам-1 алтны шороон ордыг ил аргаар ашиглах” төсөл

**Төслийн зорилго:** Уул уурхайн үйлдвэрлэл хөгжүүлж алт олборлох

**Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн дугаар:** MV-013421

**Төслийн талбайн байршил:** MV-013421 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбай нь Увс аймгийн Тариалант сумын нутаг Улаан ам хэмээх газар. [УлаанбаатарУБ](#) хотоос баруун хойд зүгт 1350 км-т, Улаангом хотоос баруун тийш 60 км, Тариалант сумын төвөөс баруун урагш 30 км-т тус тус байрлана.

Хүснэгт 1. Төслийн талбайн координат цэг

№	Уртраг	Өргөрөг
1	91° 44' 52.11"	49° 32' 20.78"
2	91° 44' 52.11"	49° 32' 32.07"
3	91° 44' 50.46"	49° 32' 33.28"
4	91° 44' 42.05"	49° 32' 36.78"
5	91° 44' 27.01"	49° 32' 36.78"
6	91° 44' 27.01"	49° 32' 20.78"



Зураг 1. Төслийн талбайн байршил

### 1.2. Төслийн товч танилцуулга

“Нэтэнг” ХХК нь Увс аймгийн Тариалан сумын нутагт орших MV-013421 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй алтны шороон ордыг ил аргаар ашиглахаар төлөвлөн ажиллаж байна. Тус тусгай зөвшөөрлийн талбайн нөөцийг ЭБМЗ-ийн 2018 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн хурлын ХХ-04-04 тоот дүгнэлтийг үндэслэн гаргасан АМГТГ-ын даргын 2018 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн н/36 дугаар тушаалаар алтны ордын нөөц нь бодитой В зэргээр химийн 58.38 кг, боломжтой (С) зэргээр химийн цэврээр 1.82 кг бөгөөд нийт (В+С) зэргээр 60.2 кг нөөцийг бүртгэсэн байна.

Уурхайн ашиглалтын хугацаа 2 жил бөгөөд дээрх хугацаанд нийт 725.86 мян.м<sup>3</sup> хөрс хуулж, 68.66 мян.м<sup>3</sup> элс олборлон баяжуулж 56.74 кг алт борлуулахаар төлөвлөсөн ба уурхайн жилийн хүчин чадал 40.0 мян.м<sup>3</sup>, хөрс хуулалтын итгэлцүүр 10.6м<sup>3</sup>/м<sup>3</sup> байна. Тус уурхайг автотээвэртэй, гадаад дотоод овоолготой ашиглалтын системээр ашиглах бөгөөд ашиглалтын явцад Doosan DX-500 маркийн экскаватор 1ш, Doosan DX-250 маркийн экскаваторт 1ш, 25 тн даацтай Howo-290 автосамосвал 3ш, Shantui SD32 бульдозер 1ш, SEM-650 маркийн утгуур ачигч 1ш зэрэг үндсэн тоног төхөөрөмжүүдийг ашиглахаар төлөвлөсөн. Төслийн хугацаанд

4888.3 сая төгрөгийн борлуулалтын орлого олж, 2945.7 сая төгрөгийн зардал гарган, 1942.6 сая төгрөгийн цэвэр ашиг олж орон нутгийн төсөвт нийт 779.84 сая төгрөгийн татвар төлбөр хэлбэрээр төвлөрүүлэн, 44 хүнийг ажлын байраар хангахаар байна.

### 1.3. Уурхайн календарчилсан төлөвлөгөө

Уулын ажлын жилийн хүчин чадал, ордыг ашиглах хугацаатай уялдуулж дараах календарчилсан төлөвлөгөөг тооцоолов. Уурхайн хил хязгаар дотор нийт 725.86 мян.м<sup>3</sup> хөрс хуулж, 68.66 мян.м<sup>3</sup> алттай элс олборлон баяжуулахаар байна. Хөрс хуулалтын коэффициент дунджаар 10.6 м<sup>3</sup>/м<sup>3</sup> байна. Ашиглалтын хугацаанд уурхайгаас нийт 794.5 мян.м<sup>3</sup> уулын цул хөдөлгөх бөгөөд дунджаар 903 мг/м<sup>3</sup> агуулгатай элс олборлон, технологийн хаягдал тооцоод химийн цэврээр 51.53 кг алт олборлон борлуулахаар төлөвлөж байна.

### 1.4. Уурхайн ажиллах горим

**Ажиллах горим.** Уурхайн ажиллах горимыг 2022 оны уурхайн хүчин чадал, жилд гүйцэтгэх уулын ажлын хэмжээ, ордын ашиглалтын нөхцөл зэргээс хамааруулан дулааны улирлын 3 сар буюу 60 хоногийн хугацаанд, өдөрт 8-10 цагийн үргэлжлэлтэй 2 ээлжээр ажиллуулахаар төлөвлөөд байна. Уурхай нь цэвдэгтэй тул 5-р сараас эхэлэн (цэвдэгтэй тул) уурхайн бэлтгэл үржил шимт хөрс хуулалтын ажлыг гүйцэтгэж, 8-р сарын 1-нээс 10-р сарын 1 хүртэл ажиллахаар төлөвлөв. Уурхай нь улирлын чанартай үйл ажиллагаа явуулах үед тасралтгүй ажиллана. Харин улсын чанартай баяр ёслолын өдрүүдэд амрахаар төлөвлөсөн.

Хүснэгт 2. Жилд ажиллах хоног

Үзүүлэлт	2022 онд
Жилийн хуанлийн хоног	365 хоног
Жилд ажиллах хоног	60 хоног
Амралт, баяр ёслолын бдрүүд	2 хоног
Урсгал засвар хийх өдрүүд	5 хоног
Цаг агаарын хүндрэл тооцох өдрүүд	3 хоног
Жилийн бодит ажиллах хоног	50 хоног
Элс угаах ажлын хоног	50 хоног
Ээлжийн тоо	2 ээлж
Нэг ээлжийн үргэлжлэх хугацаа	8-10 цаг

#### 2022 онд явагдах уулын ажил.

### 1.5. Уулын ажлын төлөвлөгөө

Уурхайн бэлтгэл ажил 2023 оны 07-р сарын 1-ээс эхлэх бөгөөд бэлтгэл ажлын хүрээнд техник тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах, зарим шаардлагатай засвар үйлчилгээний ажлууд хийгдэнэ.

Тухайн жилд ашиглах блокийн шимт хөрсийг ялган бульдозероор түрж блокын хилийн гадна гадаад овоолгод байршуулж үндсэн хөрсийг экскаватор, автосамосвал ашиглан өмнөх жилд үүсгэсэн уурхайн хоосон орон зайд шилжүүлэн байршуулахаар төлөвлөв.

Орд нь харьцангуй бага гүний орд тул ашиглалтын ажилтай зэрэгцэн олборлолтын хажуугаар техникийн нөхөн сэргээлтийг хийх бөгөөд олборлосон орон зайд дотоод овоолго хийх хэлбэрээр гүйцэтгэх боломжтой байна.

2023 оны ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр 6-В, 7С гэсэн блокуудыг бүхэлд нь, 7-В, 8-С гэсэн блокуудыг хэсэгчлэн олборлохоор төлөвлөсөн. Энэ үед уулын ажилд 5.2 талбайн гадаргуу өртөхөөр байна. 2023 онд дээрхи блокуудаас 348 мян.м<sup>3</sup> хөрс хуулж, дунджаар 730 мг/м<sup>3</sup> агуулгатай 36.57 мян.м<sup>3</sup> элс олборлон баяжуулж 22.79 кг алт /химийн цэврээр/ гарган борлуулахаар байна.

### 1.6. Ил уурхайн ашиглалтын систем

Ордын уул техникийн нөхцөл, элсний биетийн хэлбэр ба байршил, хөрсний зузаан зэрэг нь ордыг ил уурхайн аргаар, автотээвэртэй гадаад болон дотоод овоолготой, ашиглалтын системээр ашиглах үндэслэл болж байна.

**Доголын өндөр:** Улаан ам - 1алтны уурхай нь хамгийн ихдээ 7.8 м гүнзгийрэх ба хөрсний бат бөх нь 1-2 орчим мөн агуулагч чулуулаг нь ихэнхдээ сул элс, шаварлаг хурдас байгаа учир доголын өндрийг 3.5 м-ээр сонголоо.

**Ажлын бус доголын өндөр:** Ил уурхайн хүрээ хязгаарт хүрсэн үед ажлындоголоудыг нэгтгэн ажлын бус догол үүсгэнэ. Ажлын бус доголын өндөр 7м байна.

**Ил уурхайн ерөнхий хажуугийн өнцөг:** Улаан ам - 1” алтны шороон ордын агуулагч чулуулаг нь ихэвчлэн муу мөлгөржсөн хайрга, дайрга агуулсан шавар, шавранцраас бүрдэх ба чулуулгийн бүлгийн тодорхойлолтоор II бүлгийн сул, холбоос муутай чулуулагт хамаарч байна. Дээрх хүснэгтүүдийн үзүүлэлтүүдээс хамааран ил уурхайн хажуугийн тогтворжилтыг хангах үүднээс хаалтын доголын өндөр 7 м, ажлын бус хажуугийн өнцөг 50<sup>0</sup>, ил уурхайн ерөнхий налуу 40<sup>0</sup>-45<sup>0</sup> байхаар төлөвлөв.

*Хүснэгт 3. Ашиглалтын системийн үндсэн элементүүд*

№	Үзүүлэлтүүд	Нэгж	Тоо, хэмжээ
1	Хөрсний доголын өндөр - Хаалтын догол - Хөрсний догол	м	
	Элсний догол /давхаргын зузаанаар/	м	0.7-0.9
2	Доголын хажуугийн өнцөг - Ажлын догол - Ажлын бус - Ил уурхайн ерөнхий налуу	градус	- 55 - 50 - 39-45
3	Дээд доголын хормойгоос замын тэнхлэг хүртэлх зай	м	1.2
4	Автозамын тэнхлэг хоорондын зай	м	5.0
5	Замын тэнхлэгээс доод доголын ирмэгийн нурах хил хүртэлх зай	м	1.2
6	Ажлын талбайн өргөн	м	31
7	Экскаваторын орлын өргөн	м	10
8	Фронтын урт	м	<100/блокийн өргөнөөс хамаарна/
9	Граншейн замын өргөн	м	8
10	Граншейн замын налуу	%	80

**Ил уурхайд ажиллах үндсэн техник, тоног төхөөрөмж, бүтээлийн тооцоо.** “Улаан ам-1” уурхайн уулын ажилд шаардлагатай үндсэн болон туслах техник, тоног төхөөрөмжүүдийг “Шинэст өргөө” ХХК-ийн өөрийн эзэмшлийн техник тоног төхөөрөмжүүдээс шаардлагатайг сонгон ашиглахаар тооцоолж төлөвлөв. Үүнд:

*Хүснэгт 4. “Шинэст өргөө” ХХК-ийн өөрийн эзэмшлийн тоног төхөөрөмжүүдийн жагсаалт*

Д/д	Тоног төхөөрөмжийн нэр төрөл	Тоон үзүүлэлт, хэмжих нэгж	Тоо, ширхэг
1	Экскаватор DOOSAN DX500	3.0 м <sup>3</sup>	1
2	Экскаватор DOOSAN DX250	1.2 м <sup>3</sup>	1
5	Автосамосвал HOWO-290	25 тн	3
6	Бульдозер Shantui SD32	5 м <sup>3</sup>	1
7	Утгуурт ачигч SEM-650	3.0 м <sup>3</sup>	1
8	Угаах төхөөрөмж /Скруббер-30/	30 м <sup>3</sup> /ц	1
<b>НИЙТ</b>			<b>9</b>

Уурхайн хөрс хуулалт болон элс олборлолтын ухаж ачих ажилд ажиллах экскаваторуудын техникийн тодорхойлолт, бүтээлийн тооцоог доорх хүснэгтүүдээр үзүүлэв.

*Хүснэгт 5. Хөрс хуулалт, элс олборлолтонд ажиллах экскаваторын техникийн үзүүлэлт*

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоон үзүүлэлт	
			DX500	DX250
	Марк		DX500	DX250
1	Утгуурын багтаамж	м <sup>3</sup>	3.0	1.2
2	Утгалтын хамгийн их радиус	м	10.8	6.9
3	Утгалтын хамгийн их гүн	м	7.2	6.6
4	Ачих хамгийн их өндөр	м	7.6	5.6
5	Явах хамгийн их хурд	км/цаг	5	5
6	Явах ангийн урт	м	5.4	5.4
7	Явах ангийн өргөн	м	3.9	3.9

8	Их биеийн өндөр	м	3.4	3.4
9	Явах ангийн гинжний өргөн	с	0.6	0.6
10	Хөдөлгүүрийн чадал	кВт	232	110
11	Жин	тн	50	21.5
12	Түлш зарцуулалт	л/цаг	35	22

*Хүснэгт 6. Эскаваторуудын бүтээл, хэрэгцээний тооцоо*

Д/д	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	
			2022 он	
			Хөрс	Элс
1	Ашиглалтын нөхцөл	-		Хэвийн
2	Эскаваторын утгуурын багтаамж, E	м <sup>3</sup>	3.2	1.2
3	Эскаваторын мөчлөгийн хугацаа	сек	32	23
4	1 цагт хийх мөчлөгийн тоо	мөчлөг	113	157
5	Утгуур дүүргэлтийн коэффициент	-	1	1
6	Утгуур дахь чулуулгийн сийрэгжилтийн коэффициент	-	1.1	1.1
7	Эскаваторын цагийн бүтээл	м <sup>3</sup>	327.3	170.8
8	Эскаваторын ээлжийн бүтээл	м <sup>3</sup>	3272.7	1707.5
9	Бүтээлд нөлөөлөх хүчин зүйлүүд			
	Цаг ашиглалтын коэффициент	-	0.9	0.85
	- Операторчийн ур чадварыг тооцсон коэффициент	-	0.95	0.85
	- Эскаваторын шилжилт, нүүдэл тооцсон коэффициент	-	0.95	0.85
10	Эскаваторын ээлжийн бүтээл /10 цагаар/	м <sup>3</sup>	2658.3	1048.6
11	Эскаваторын хоногийн бүтээл	м <sup>3</sup>	5316.5	2097.2
12	Уурхайн жилд ажиллах хоногийн тоо	хоног	80	70
13	Эскаваторын жилийн бүтээл	мян.м <sup>3</sup>	425.32	146.81
14	Уурхайн жилд гүйцэтгэх ажлын хэмжээ	мян.м <sup>3</sup>	374.4	36.65
15	Эскаваторын тооцооны тоо	шир	0.88	0.25
16	Эскаваторын дансны тоо (К-1.2)	шир	1	1
17	Нийт эскаваторын жилд ажиллах цаг	мото.цаг	1142.9	214.6


Тооцооноос уурхайн хөрс хуулалтанд Doosan DX500 маркын 1 ш эскаватор, харин элс олборлолтонд Doosan DX250 маркын 1 ш эскаватор байхад бүтээл болон нөөцийн хувьд бүрэн хүрэлцээтэй байна.

### 1.7. Баяжуулах технологи

Угаан баяжуулах цех нь нийт 3 сарын хугацаанд 36.66 мян.м<sup>3</sup> элс угаан баяжуулах бөгөөд дулааны улиралд ажил явагдана. Угаан баяжуулах цехийн цагийн хүчин чадлыг дараах томъёогоор олсон. Баяжуулах технологит ашиглах СБ-30 маркын 30 м<sup>3</sup>/цаг хүчин чадалтай угаах төхөөрөмжийн ээлжийн бүтээлийг дараах байдлаар тооцоолов.

**Угаан баяжуулах цехийн тоног төхөөрөмж.** Угаан баяжуулах цехийн тоног төхөөрөмжийг элс олборлолтын төлөвлөгөө, технологийн туршилтын үр дүн, технологийн тооцооллын үр дүнд үндэслэн тоног төхөөрөмжийн хүчин чадал, сэлбэг хэрэгслийн хангамж, үйл ажиллагааны зардал бага зэрэг нөхцөлүүдийг харгалзан үзэв.

Тоног төхөөрөмжийн сонголтыг хийхдээ төсөл захиалагчаас ирүүлсэн ажлын даалгаварт нийцүүлсэн. Элс угаан баяжуулах технологид угааж ангилах скруббер, гидрошлюз, баяжуулах ширээ, насос зэрэг тоног төхөөрөмжүүдийг ашиглана. Угаан баяжуулах цехийн тоног төхөөрөмжийн холболт болонзургийн тайлбарыг доор үзүүлэв.



Зураг 2. Угаан баяжуулах цехийн тоног төхөөрөмжийн холболтын бүдүүвч

**Усан хангамж ба уурхайн ус зайлуулалт:** Байгаль орчныг хамгаалах, цэвэр усны нөөцийг хэмнэх зорилгоор уурхайн технологийн усан хангамжинд хэрэглэгдэх усыг хуримтлуулж, цэвэршүүлэх замаар эргүүлэн ашиглах хэрэгтэй. Битүү эргэлтийн системээр усыг ашиглахад хаягдлын болоод цэвэр усны санг байгуулах шаардлага гардаг. Ордын элс нь хялбар угаагдах шинж чанартай учир  $1 \text{ м}^3$  элс угаахад  $4 \text{ м}^3$  ус хэрэглэхээр тооцоолов. Баяжуулах хэсгийн цэвэр, тунаах, бохирын нууруудыг уурхайн урд талд 100м зайд үүсгэнэ. Шинээр үүсэх нууруудын багтаамжийг доорх хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 7. Нуурын багтаамж

Д/д	Нуурын нэр	Нуурын талбай $\text{м}^2$	Нуурын гүн, м	Нуурын эзлэхүүн мян. $\text{м}^3$
1	Цэвэр	1597	3.5	5.6
2	Тунаах	963	3.0	2.9
3	Бохир	1197	3.0	3.6

## 2. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 2.1. Цаг уур, уур амьсгал

Увс нуурын сав газар Хархираа Түргэний салбар уулсын муж нь уур амьсгалын хувьд Монгол орны бусад нутгаас эрс тэс, хатуу ширүүн нөхцлөөрөө хавьгүй илүү бөгөөд хамгийн хүйтэн, хуурай уур амьсгал 10 дугаар сараас 5 дугаар сар хүртэл үргэлжилнэ. Харин хаврын улиралд тогтвортой эсрэг циклон алдагдаж, улмаар зун нь их халуун болдог. Гэхдээ хархираа, Түргэний уулс, Хан Хөхийн нуруунд өвлийн тогтвортой циклон үүсдэггүй. Тэнд В.М.Фриландын илрүүлсэн (1959) уулсын хаяа бэлийн чийглэг бүсийн онцлогтой холбоо бүхий температурын ондоо инверс бий болдог. Иймд уур амьсгалын нөхцөл нь хотгорынхоос ондоо, арай зөөлөвтөр шинж чанартай байна. Увс нуурын хотгор, Хан Хөхий нурууны ар хажуу, Тэсийн голын сав дагуу жилийн дундаж температур маш бага ( $-10^{\circ}\text{C}$   $+8^{\circ}\text{C}$ ), Хахираа, Түргэний уулсаар арай дулаан ( $1.8^{\circ}\text{C}$   $-3.6^{\circ}\text{C}$ ) болдог.

Хур тунадасны хувьд жилд дунджаар 160-200мм орчим тунадас унах бөгөөд төслийн талбайн орчин нь говийн бүсээс хээр, ойт хээрийн бүсэд шилжих шилжилтийн бүсийн заагт орших тул жил бүрд унах тунадасны хэмжээ харилцан адилгүй, олон жилийн мэдээллээс харахад өсөх хандлагатай байна.

Талбай нь эх газрын эрс тэс хуурай уур амьсгалтай богино зунтай, урт өвөлтэй, хамгийн хүйтэн нь 1-р сард  $-20^{\circ}\text{C}$ -аас  $-35^{\circ}\text{C}$ , хамгийн халуун нь 7-р сард  $+18^{\circ}\text{C}$ -аас  $+25^{\circ}\text{C}$  байх ба жилдээ 160-180 мм хур тунадас унана. 10-р сарын дунд үеэс 5-р сарын эх хүртэл цасан бүрхүүл тогтоно. 11-р сарын эхээр газар хөлдөж эхлэх бөгөөд хөрсний хөлдөлтийн гүн нь 3м хүрнэ. Нуур гол горхиуд нь ихэвчлэн байгалийн хур бороо гадаргуугийн усаар тэжээгдэх бөгөөд 10-р сарын дунд үеэс хөлдөж 5-р сарын эхээр гэнэнэ.

### 2.2. Усан сүлжээ

Судалгааны талбайн орчин нь гадаргын усан сүлжээ харьцангуй сайн хөгжсөн бөгөөд Бургастайн гол түүний цутгалууд Баруун, Зүүн салааны, Толгийн салаа, Хорхойтын, Талын салаа, Шивээн гол, Цагаан усны гол зэрэг байнгын усгалтай голууд, Үнэгт, Дайв, Хайчийн зэрэг байнгын бус устай сайрууд, Сэрүүний хаг, Хөсөрийн хар нуур, Холбоо нуур зэрэг жижиг шорвог нуурууд байдаг.

Төслийн талбайд хамгийн ойр орших гадаргын ус болох Баруун салаа голоос авсан дээжинд хийсэн шинжилгээний дүнгээс харахад химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонат ангийн, кальци, натрийн бүлгийн, 1-р төрлийн, чанарын хувьд нэн, маш зөөлөн ус байна. Шинжилсэн химийн үзүүлэлтүүд “Усан орчны ерөнхий шаардлага, MNS 4586:1998” стандартын шаардлага хангасан боловч “Гадаргын усны цэврийн зэргийн ангиллын норм”-той харьцуулбал перманганатын исэлдэх чанарын хэмжээгээр “Бага зэрэг бохирдолтой” байна. Ундны усны стандарт “MNS 0900:2005”-тай харьцуулбал зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрээгүй бөгөөд унданд хэрэглэх тохиолдолд шүүж, цэвэршүүлж хэрэглэх нь зүйтэй байна.

### 2.3. Хөрсний төлөв байдал

Төслийн талбай нь ботаник- газарзүйн мужлалаар Евро-азийн хээрийн мужийн Дагуур монголын (Төв Азийн) дэд муж дах Алтайн умард уулархаг мужийн Их нууруудын хотгорын дэд мужид хамаарагдах бөгөөд энд хангайн бүсийн хар хүрэн өнгийн шаварлаг, элсэрхэг хөрс голлон тархана. Энэ бүсэд зонхилох хар хүрэн хөрс нь ялзмагийн зүйл ихтэй, их зузаантай (2-9 м орчим) чийг хадгалалт сайтай байдаг.

### 2.4. Амьтны аймаг

Төслийн талбай нь Физик газарзүйн мужлалаар Хойд говийн тойрогт хамаарна. Энд

тохиолдох боломжит 42 зүйл хөхтөн, 82 зүйл шувуу, 6 зүйл хоёр нутагтан байна. Оросын шувуу судлаач В.И.Забелины тодорхойлсноор Увс нуурын ай савд 359 зүйл шувуу, эдгээрээс өвөлждөг 8 зүйл, дайрч өнгөрдөг 82 зүйл шувуу амьдрах боломжтойг тогтоосон байдаг. Тариалан сумын нутагт байрлах “Улаан ам-1 хайгуулын талбайн орчимд уулын, ойн, тал хээрийн амьтад зонхилно. Энд буга, янгир, аргаль, ирвэс, шилүүс, дорго, нохой зээх, гахай зэрэг ховор амьтад нутагладаг. Судлаач С.Амгаланбаатарын харьцуулан судалснаар 245 зүйл шувуу байдаг нь тогтоогджээ.

### **2.5. Тариалан сумын нийгэм эдийн засгийн судалгаа**

2016 онд тус суманд 904 өрх, 3873 хүн амтай үүний 0-18 насны хүүхэд 1476, 60-аас дээш насны ахмадууд 211, хөдөлмөрийн насны 2186 хүн амьдардаг. Сум нь 126 293 толгой малтай хөдөөний 4, төвийн 2 багтай нийт хүн амын 89.3% нь үндэсний цөөнх хотон ястан амьдардаг. Эдийн засгийн голлох салбар нь нүүдлийн мал аж ахуй, ардын уламжлалт газар тариалан юм. Тус сумын газар нутаг алт, нүүрс, төмрийн хүдэр зэрэг байгалийн баялагаар элбэг бөгөөд одоо алтны нөхөн сэргээлтийн 4, нүүрсний 2 компани тус тус олборлолт хийж үйл ажиллагаагаа явуулж байна.

### 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Төслөөс байгаль орчинд учирч болзошгүй сөрөг нөлөөлөл нь багаас дунд зэрэг байх бөгөөд төслийн технологит ашиглагдаж буй техникийн хэрэглээг буруу ашигласнаас эвдрэл үүсэх мөн угсралтыг буруу гүйцэтгэх, санамсар болгоомжгүй байдлаас гал түймэр гарах зэрэг нь байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд сөрөг нөлөөлөл үзүүлэхээр байна.

Агаар: Алтны шороон ордын төслийн үйл ажиллагаанаас агаар орчинд хөрс хуулах, элс угаах болон дэд бүтцийн хэсгээс сөрөг нөлөөлөл үүсэхээр байна. Эдгээр нь хөрс хуулах, ачиж буулгах, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, хөдөлгүүрээс үүсэх тоос шороо болон хийн хаягдал байх юм. Төслийн үйл ажиллагаанаас үүсэх тоосжилтын хэмжээг бууруулах гол ажил нь тээврийн хэрэгслүүдийг тогтсон нэг зам маршрутаар явуулах, уурхайн дотоод замыг услаж чийгшүүлэх, салхи багатай өдрийн цагийг үр бүтээлтэй ашиглах.

Ус: Улаан ам-1 нэртэй алтны шороон ордыг төслийн талбай нь гадаргын устай ойр, төслийн үйл ажиллагаанд гадаргын ус ашиглах зэрэг нь элс угаан баяжуулах ажлын үед гадаргын усанд үзүүлэх сөрөг нөлөөлөл их байх нөхцлийг бүрдүүлж байна. Ажилчдын унд ахуйн хэрэглээнд мөн гадаргын усыг ашиглах бөгөөд энэ нь хэмжээ бага тул нөлөөлөл бага юм. Гадаргын усанд үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөллүүд нь хатуу, шингэн хог хаягдлыг зориулалтын хөрсөнд ус нэвчихээргүй байгууламжид хураан харимтлуулаагүйгээс хөрсөөр болон салхиар дамжин гадаргын усыг бохирдуулах, ажилчид хувцас, машин техникийг голын усанд угааж бохирдуулах зэрэг болно.

Хөрс: Төслийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөлөл их байх бөгөөд нөлөөлөлд өртөх объект нь уулын ажилд өртөх талбай, элс угаан баяжуулах цехийн үйл ажиллагаанд өртөх талбай, дэд бүтцийн байгууламжуудад өртөх талбайн хөрсөн бүрхэвч хамаарна. Үүнээс гадна хатуу болон шингэн хог хаягдлын ил задгай хаях, ШТМ газрын гадаргад алдах зэргээс хөрсөн бүрхэвчийг бохирдуулах, олон салаа зам гарган талхагдалд оруулах зэрэг сөрөг нөлөөллүүд үүсэж болзошгүй.

Ургамал: Төслийн бүхий л шатны үйл ажиллагаанаас ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөлөл хамгийн их байна. Үүнээс гадна хатуу шингэн хог хаягдлыг ил задгай хаях, олон салаа зам гаргах, тоосжилт ихээр үүсгэх, уурхайн тухайн жилийн төлөвлөлтийн хэмжээнээс хэтрүүлэн газар хөндөх зэргээр ургамлан нөмрөгийг талхагдалд оруулах, фотосинтезийн эрчмийг бууруулах сөрөг нөлөөлөл учруулж болзошгүй юм.

Амьтан: Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлэх шууд сөрөг нөлөөлөлгүй бөгөөд төслийг хүчин чадлаас хэтрүүлэн ажиллах, ажилчид хулгайн ан хийх, их хэмжээний давтамж бүхий дуу чимээ үүсгэх, уурхайн ухааш, хиймэл нуур зэрэгт хаалт хашилт хийгээгүйн улмаас мал, амьтан унаж бэртэх сөрөг нөлөөллүүд үүсэж болзошгүй байна.

Хүснэгт 8. Болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээний нэгдсэн дүн

№	Нөлөөлөл	Үнэлгээ							
		Эерэг				Сөрөг			
		Бүгд	Их	Бага	Дунд	Бүгд	Их	Бага	Дунд
1	Газрын гадарга					4	1		3
3	Агаарын чанар					4		2	2
4	Усан орчин					4		4	
5	Хөрсөн бүрхэвч					5	1		4
6	Ургамалан нөмрөг					6	3		3
7	Амьтны аймаг					3			3
8	Нийгэм, эдийн засаг	4	1		2				1

#### **4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ**

Тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөний үндсэн зорилго нь “Шинэст өргөө” ХХКийн “Улаан ам-1” алтны шороон ордыг ашиглах төслийн үйл ажиллагаанаас төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчин болон төслийн ажилчид, ойр орчмын оршин суугчид, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, тухайн орчныг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, тус төслийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэхэд оршино. Энэ хүрээнд

1. Тус төслийн шууд ба шууд бус сөрөг нөлөөллийг бууруулах, улмаар арилгах, нөхөн сэргээх үйл ажиллагааг тусгасан сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, хог хаягдлын менежментийн төлөвлөгөө, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын талаар авах арга хэмжээ зэргийг тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө
2. Мөн тус төслийн байгаль хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ хэрхэн үр дүнтэй болсон эсэх, шаардлагатай үед нэмэлт арга хэмжээ авах зорилгоор төслийн үргэлжлэх бүхий л хугацааны турш хэрэгжүүлэх орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг тус тус боловсруулсан болно.

Тус төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дүгээр сарын 29-ны өдрийн А-618 тоот тушаалаар батлагдсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын дагуу батлагдсан аргачлалыг баримтлан боловсруулсан бөгөөд төслийн үйл ажиллагааны онцлог, байршил зэргээс шалтгаалан байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ, түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө зэрэг ажлууд хийгдэхгүй болно. Харин нөхөн сэргээлтийн төлөвлөгөө болон хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг тус тус оруулсан болно. Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, хог хаягдлын менежментийн төлөвлөгөө, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын талаар авах арга хэмжээ, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан бөгөөд төсөл хэрэгжүүлэгч нь жил бүрийн 12 дугаар сарын 10-ны дотор тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төслийн хамт холбогдох байгууллагад хүргүүлж байх зайлшгүй шаардлагатай болно.

## 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

### 5.1. Ордын ашиглалтын үед сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 9. Ордын ашиглалтын үед сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

	Болзошгүй сөрөг нөлөөллүүд	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг,стандарт аргачлал
1	<b>АГААР ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ БАГАСГАХ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ</b>					
	Уурхайн олборлолт болон тээврийн хэрэгслүүдийн үйл ажиллагааны улмаас гарч болох тоосжилтын эх үүсвэрүүд: ✓ Уурхайн олборлолтын үеийн хөрс хуулалт, олборлолт, овоолго хийх газар шорооны ажил, ✓ Уурхайн үйл ажиллагаанд ашиглаж буй тээврийн хөдөлгөөн, тээвэрлэлтэнд явж буй машинуудаас ялгарах хорт бодисуудаар орчны агаар бохирдох	Хуурайшилт ихтэй өдрүүдэд усалгаа хийх, усалгаандаа барьцалдуулагч бодис ашглах	Уурхайн ухаш, хөрсний овоолго зам	500.0	Уурхайн үйл ажиллагааны үед, нөхөн сэргээлтийн үе шатуудад	Агаарын ба агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, MNS 0017-2-3-16:1998 (хүн ам суурьшсан хэсгүүдэд) Бензин хөдөлгүүрт MNS 5013:2003 Дизель хөдөлгүүрт MNS 5014:2003 /ЗГ-ын 2013 оны 327 дугаар тогтоолын хавсралт- Ус ашигласны төлбөрийн хувь хэмжээ/ /БО-ны сайдын 1995 оны 153 дугаар тушаалын хавсралт 4-“Зүлэг, талбай усалгааны түр норм Бензин хөдөлгүүрт MNS 5013:2003 Дизель хөдөлгүүрт MNS 5014:2003
		Уурхайн дотоод тээврийн замыг тогтмол засаж сайжруулах, нягтаршуулах	Уурхайн дотоод зам	-		
		Уурхайн тээвэрлэлтийн замын тогтмол маршрутыг төлөвлөж, шаардлагагүй олон салаа зам гаргахгүй байх	Уурхайн тээвэрлэлтийн зам	-		
		Уурхайн түр шороон зам дагуу MNS 4597:2014 стандартын дагуу замын тэмдэг тэмдэглэгээг байршуулах	Уурхайн тээвэрлэлтийн зам	100.0		
		Уурхайн замд тээврийн хэрэгслийн хурдыг хязгаарлах зохицуулалт хийх (уурхайн дотоод зам дээр ачаатай тээвэрлэлт хийхдээ хурдны хязгаарыг 20км/цагт тогтмол барих ба ачаагүй үед 30км/цагт барих)	Уурхайн тээвэрлэлтийн зам	-		
		Уурхайн олборлолтын талбай, түр зам, ажилчдын кемп зэрэг газруудад агаарын тоосжилтын хэмжилтийг тогтсон хуваарийн дагуу хийх, хэмжилтийн үр дүнг хянаж, зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд тоос бууруулах арга хэмжээг авах	Ухаш, уурхайн түр зам, ажилчдын кемп	-		
	Тээврийн хэрэгслүүдийн орчны агаарт бий болгох бохирдлыг багасгах үүднээс засвар үйлчилгээг тогтмол хуваарийн дагуу хийх, ашиглалтын хугацаа дууссан, утаа ихээр ялгаруулдаг машин техникийг үйл ажиллагаанд ашиглахгүй байх	Уурхайн машин техникүүд	-			
	<b>Нийт дүн</b>			<b>600.0</b>		
	<b>Болзошгүй сөрөг нөлөөллүүд</b>	<b>Нөлөөллийг бууруулах арга хэмжээ</b>	<b>Арга хэмжээний цар</b>	<b>Зардал /мян.төг/</b>	<b>Хэрэгжүүлэх хугацаа</b>	<b>Баримтлах эрх зүйн баримт бичиг,стандарт аргачлал</b>

3. ГАЗРЫН ГАДАРГА, ХӨРСӨН БҮРХЭВЧИД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУЛАХ БАГАСГАХ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ						
Хөрс хуулах, олборлох, овоолго байгуулах явцад ургамал талхлагдан хөрс эвдрэлд орж, газрын тогтоц, хэлбэр, төрх өөрчлөгдөж, ухагдаж эвдэрнэ. Олон салаа зам гарснаас хөрсөн бүрхэвчийн элэгдэл, эвдрэлийн эрчим нэмэгдэнэ. Биологийн нөхөн сэргээлтийн ажлын үр дүн шимт хөрсний чанараас хамаарна. Шимт хөрсний чанар муу байх нь нөхөн сэргээлтийн ажлыг үр дүнгүй болгож экосистемд сөрөг нөлөөлөл үзүүлнэ. Ашиглалтын хугацаанд нийт олборлолт, овоолго, дэд бүтцийн барилга байгууламж зэргээр нийт 16 га талбай эвдрэлд өртөнө.	Хог хаях, шатах тослох материал асгах, хөрсний бохирдол үүсгэхээс сэргийлэх, олон салаа зам гаргахгүй байх талаар жолооч операторуудад сургалт явуулах	Бүх жолооч, операторууд	-	Үйл ажиллагааны үе шатуудад	MNS 5914:2008- Байгаль орчин. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томъёо, тодорхойлолт. MNS 5915:2008- Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал MNS 5916:2008- Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсийг хуулах, хадгалах техникийн шаардлага MNS 5917:2008- Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн шаардлага MNS 5918:2008- Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн шаардлага. MNS 4915:2000- Ашигт малтмал эрж хайх явцад эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн шаардлага. MNS 4920:2000- Эвдэрсэн газрын хажуугийн налуу. Техникийн шаардлага	
	Автомашинны зогсоолыг цементэн хучилттай болгох	2023 он	1500.0 ҮА зардал			
	Уурхайн дотоод болон гадаад тээврийн замын дагуу шаардлагатай газруудад тэмдэг тэмдэглэгээ байршуулах	2023 он	-			
	Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсний хуулалт, хадгалалт, овоолгыг MNS 5916:2008 (Байгаль орчин. Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт) стандартын дагуу хийж, тусад нь овоолго үүсгэн хадгалах	24.55мян.м <sup>3</sup> шимт хөрс	300.0			
	Ашиглалтын хугацаа дууссаны дараа уурхайн үйл ажиллагаагаар эвдрэлд өртсөн 16 га газрыг байгалийн бүтэц онцлогт нь нийцүүлэн техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг хийх	Эвдрэлд өртсөн талбайд	Нөхөн сэргээлтийн зардал			
<b>Нийт дүн</b>				<b>300.0</b>		
Болзошгүй сөрөг нөлөөллүүд	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт аргачлал	
3 УСНЫ НӨӨЦ, ЧАНАРТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУЛАХ БАГАСГАХ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ						
Уурхайд нийт шаардлагатай ус нь 105.94 мян.м <sup>3</sup> буюу хоногийн усны хэрэглээ нь нийт 412м <sup>3</sup> буюу 4.7л/сек байна. Уурхайгаа тойруулан үерийн далан байгуулах	Ус ашиглах гэрээ, боломжит нөөцийн дүгнэлтэд заасан хэмжээнээс хэтрүүлэн ашиглахгүй байх	“Шинэст өргөө” ХХК	-	2023 оноос	MNS 0900: 2019, “Ундны усны чанарын стандарт” Ус ашигласны төлбөр (Засгийн газрын 2005 оны 7-р тогтоол) MNS 4943:2015 “Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус.	
	Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөж ажиллах		-	2023 онд		
	Үерийн далан болон усны барилга байгууламжийн зураг төслийг мэргэжлийн байгууллагаар хийлгэх		1000.0 ҮА зардал	Үйл ажиллагаа эхлэхээс өмнө		

“Улаан ам-1 атны шороон ордыг ил аргаар ашиглах” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Нийт дүн			0.0		
Болзошгүй сөрөг нөлөөллүүд	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт аргачлал
<b>УРГАМЛАН БҮРХЭВЧИД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ БАГАСГАХ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ</b>					
Уурхайн үйл ажиллагаанаас нийт 16 га талбай эвдрэлд өртөж, ургамлан нөмрөг устана.	Ашиглалтын хугацаа дууссаны дараа уурхайн үйл ажиллагаагаар эвдрэлд өртсөн 16 га газрыг байгалийн бүтэц онцлогт нь нийцүүлэн нөхөн сэргээлт хийж, MNS 5918:2023 (Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага) стандартын дагуу эвдэрсэн газрыг ургамалжуулж, хяналт мониторингийн ажлыг гүйцэтгэх	Төслийн талбайн хэмжээнд	500.0	Нөхөн сэргээлтийн үед	Ургамал хамгааллын тухай хууль
Ургамлан нөмрөг уурхайн дэд бүтцийн барилга байгууламж, овоолгын доор дарагдана.	Аливаа газар хөндөлт бүрийн өмнө тухайн талбайн ургамлан нөмрөгийн суурь мэдээллийг цуглуулж, нөхөн сэргээлтийн ажилд тухайн нутгийн ургамлын үрүүдийг ашиглаж, байгалийн бүлгэмдлүүдийг дахин сэргээх арга хэмжээ авах	Төслийн талбайн хэмжээнд	300.0	-	
Машин техникийн аюулгүй ажиллагаа алдагдан шатах тослох материал асгарах улмаар ургамлан бүрхэвч бохирдож болзошгүй	Тээврийн хэрэгслүүдийн техник үйлчилгээг цаг тухайд нь зориулалтын хатуу хучилтгаай талбайд хийх	Засварын цех	-	Үйл ажиллагааны турш	
<b>Дүн</b>			<b>800.0</b>		
Болзошгүй сөрөг нөлөөллүүд	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт аргачлал
<b>АМЬТНЫ АЙМАГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ БАГАСГАХ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ</b>					
Төслийн үйл ажиллагаанаас амьтдын амьдрах орчныг удаан хугацаагаар хомсдуулах зэргээр сөрөг нөлөө үзүүлнэ.	Орд орчмын амьтны зүйлийн бүрдэл, тархац судалгаа хийх	Төслийн талбай түүний орчим	-	2023 он	Амьтны тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль
Шимт хөрсний хуулалтаар мэрэгчид, мөлхөгчид гэх мэт амьтдын амьдрах орчныг сүйтгэх	Уурхайн ашиглалтын хугацаа дууссаны дараа нөхөн сэргээлтийн ажлыг стандартын дагуу хийж гүйцэтгэх	Уурхайн ухаш, эвдрэлд өртсөн газрууд	-	-	

“Улаан ам-1 атны шороон ордыг ил аргаар ашиглах” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Уурхайн нүх карьерт амьтад орж үрэгдэх, дуу чимээний нөлөөллөөс үргэж дайжих	Уурхайн бүсэд хамгаалалтын хашаа барих	Уурхайн олборлох хэсэг	1500.0	-	
Дүн			1500.0		
<b>НИЙТ ДҮН</b>			<b>3200.0</b>		

**5.2. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө**

*Хүснэгт 10. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө, зардал*

Болзошгүй аюул осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Төслийн үйл ажиллагаанаас газрын төлөв байдал, чанар доройтно	Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг 5 жил тутамд мэргэжлийн байгууллагаар хийлгэх	MV-013421 талбай	Гэрээгээр зохицуулна.		Газрын тухай хуулийн 58.5
Усны нөөцийг үр ашигтай ашиглаагүйгээс гадаргын усны нөөц, горимд өөрчлөлт орно.	Ус ашиглах дүгнэлт гаргуулан, холбогдох газраас ус ашиглах зөвшөөрөл авах Усны барилга байгууламжийн зураг төсөл мэргэжлийн байгууллагаар хийлгэх	Гадаргын уснаас хангана	8000.0 ҮА зардал	2023 он	Усны тухай хууль
“Байгаль орчны аудит” гэж байгаль орчны хууль тогтоомж, төрийн бодлого, үндэсний хөтөлбөрийн биелэлт, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, стандартын хэрэгжилтийг хянаж, дүгнэлт гаргах, мэргэжлийн зөвлөгөө өгөх хараат бус үйл ажиллагааг хэлнэ	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10 <sup>1</sup> болон БО-ы ерөнхий үнэлгээний шаардлагын дагуу 2 жил тутамд Байгаль орчны аудит хийлгэх	2 жил тутамд	10000.0 ҮА зардрл	-	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчны аудит хийх эрх олгох журам
Ажилчдын мэдлэг чадвар дутмаг байдлаас ажлын доголдол гарах	Уурхайд ажиллаж байгаа ажиллагсдын тухайн ажлыг хийж гүйцэтгэх мэдлэг чадварыг сайжруулах зорилгоор мэргэжлийн сургаалтанд хамруулж байх	Ажилчдыг	-	Жил бүр	МУ-ын үндсэн хууль Хөдөлмөрийн тухай Эрүүл мэндийн тухай Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм Ил уурхайн аюулгүй ажиллагааны дүрэм
Уул уурхайн үйл ажиллагаанаас ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй	Ажлын байрны хэвийн бус нөхцөлд ажилладаг ажилчдыг илчлэг, витаминлаг хоол хүнсээр хангах	Бүх ажилчдыг	Үйл ажиллагааны зардалд орсон	Өдөр бүр	MNS 4990:2000 MNS 4968:2000 MNS 4994:2000
Тэр бум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд жил бүр мод тарих		Орон нутгийн саналын дагуу	2500.0 ҮА зардал	2023 он	
